



БАТЛАВ: "ДЦС-3" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
"ДЦС-4" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
"MCS ИНТЕРНЭЙШНЛ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
МЭХИХ-НЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
ШУТИС –ИЙН ЭХС-ИЙН ЗАХИРАЛ

**"ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ХӨГЖИЛ, ШИНЭ ТЕХНИК ТЕХНОЛОГИ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ" СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ОНОЛ ПРАКТИКТИКИЙН БАГА ХУРЛЫН ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

2018 оны 3-р сарын 14

Улаанбаатар хот

**НЭГ. ЗОРИЛГО**

"ДЦС-3" ТӨХК-ийн 50 жил, "ДЦС-4" ТӨХК-ийн 35 жил, "MCS интернэйшнл" ХХК-ийн 25 жил, Монголын ЭрчимХүчний Инженерүүдийн Холбоо байгуулагдсаны 20 жилийн ойн хүрээнд зохион байгуулж буй "Эрчим хүчний салбарын хөгжил, шинэ техник технологи, эрчим хүчний хэмнэлт" сэдэвт эрдэм шинжилгээ, онол практиктикийн бага хурал нь эрчим хүчний салбарт хэрэгжүүлж буй шинэ-дэвшилтэт техник, технологи болон эрчим хүчний хэмнэлтийн шийдлүүдийг онол, судалгаа шинжилгээг хэрэгжүүлсэн туршлага дээр үндэслэн хэлэлцэх.

Зохион байгуулагчид: "ДЦС-3" ТӨХК, "ДЦС-4" ТӨХК, "MCS интернэйшнл" ХХК, Монголын Эрчим Хүчний Инженерүүдийн Холбоо, ШУТИС-ЭХС.

**ХОЁР. ХУРЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ**

Хуралд өмчийн хэлбэрийг үл харгалзан эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын инженер техникийн ажилтнууд, их дээд сургуулиудын эрдэмтэн багш нар, судлаачид бие даан болон хамтарч оролцох боломжтой.

**ГУРАВ. ХУГАЦАА, ГАЗАР**

Улаанбаатар хотод 2018 оны 6-р сарын 15-ны өдөр 09.00 - 17.00 цагт хөтөлбөрт заасан хурлын танхимд болно.

**ДӨРӨВ. ИЛТГЭЛИЙН СЭДВИЙН ХАМРАХ ХҮРЭЭ**

Онол-практикийн бага хуралд тавигдах илтгэлүүд нь эрчим хүчний салбарт нэвтрүүлж буй, нэвтрүүлэх боломжтой шинэ дэвшилтэт, байгаль орчинд ээлтэй ногоон техник технологи, тэдгээрийн техникийн болоод эдийн засгийн үр ашгийн тухай, техник тоног төхөөрөмжийн насжилтыг уртасгаж ашиглалтын түвшинг сайжруулах, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

Илтгэлийн сэдвүүд дараах хүрээнд байна . Үүнд :

1. Эрчим хүчний хөгжлийн чиг хандлага
2. Шинэ техник, технологи
3. Ногоон техник, технологи
4. Эрчим хүчний хэмнэлт.

## ТАВ. ИЛТГЭЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Илтгэл нь хамрах сэдвийн агуулгын хүрээнд тоо баримт статистик үзүүлэлт ашигласан, үзэл санаагаа товч тодорхой илэрхийлж шинэ санал санаачилга тусгасан, эдийн засгийн үр ашгийг тооцсон, онол практикийн ач холбогдолтой байна.

Илтгэлийг шинээр бэлтгэж ирүүлнэ. Өмнө нь онол практикийн бага хурлуудад хэлэлцэгдсэн болон мэдээллийн төрөл сувгаар нийтлэгдсэн илтгэлийг хүлээж авахгүй болно.

Илтгэлд тавигдах ерөнхий шаардлага:

1. Microsoft office word программ ашиглан А4 цаасан дээр захын зайг зүүн талаас 30, баруун талаас 15, дээд болон доод талаас 20 мм байхаар тохируулна.
2. Arial фонд сонгон үсгийн өндрийг 12 pt, мөр хоорондын зайг 1.5 байхаар бичнэ.
3. Илтгэлд оруулсан зураг, графикийг jpg файлаар илтгэлтэй хавсаргаж явуулна.
4. Хуудас бүр дугаартай, 10 нүүрнээс хэтрэхгүй байх.

## ЗУРГАА. ИЛТГЭЛИЙГ ШАЛГАРУУЛАХ ҮЗҮҮЛЭЛТ

Илтгэлийг шалгаруулахдаа илтгэлд тавигдах ерөнхий шаардлагаас гадна дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ. Үүнд:

1. Судалгаа шинжилгээний арга зүй
2. Ашиглаж судалсан материал, эх сурвалжийн байдал
3. Дүгнэлт, санал нь бодитой, үр ашигтай, хэрэгжих боломжтой эсэх
4. Асуудал дэвшүүлж зорилгодоо хүрсэн байдал
5. Сэдвийн ач холбогдол
6. Илтгэлийн бүтэц, ерөнхий шаардлага хангасан байдал.

Шүүгчдийн бүрэлдэхүүн шалгуур тус бүрийг 1-5 оноогоор дүгнэх бөгөөд нийлбэр оноогоор байр эзлүүлнэ

## ДОЛОО. УРАЛДААНД ИРҮҮЛЭХ ИЛТГЭЛИЙН БҮРТГЭЛ БА ШАЛГАРУУЛАЛТ

Илтгэлийг 2018 оны 5-р сарын 20 хүртэл хэвлэмэл болон файлаар “ДЦС-4” ТӨХК –ийн Судалгаа Хөгжлийн Албаны galbadrakh1964@gmail.com цахим хаягаар хүлээж авна. Илтгэгч нарын товч танилцуулга, зураг 4Х6 см хэмжээтэй 300 dpi шаардлага хангасан, холбоо барих хаяг, утсаа хавсаргасан байна. Ирүүлсэн шилдэг илтгэлүүдээр ном гаргаж хэвлүүлнэ. Оролцож илтгэлээ ирүүлэх компаниуд шилдэг 3 хүртэлх илтгэл ирүүлнэ. Зохион байгуулж буй компаниудад илтгэлийн тоог хязгаарлахгүй. Холбогдох утас: 70003616 , 70111302

**Шалгаруулалт:** Ирүүлсэн илтгэлүүдийг шүүгчдийн бүрэлдэхүүн дүгнэн ДУЛААН, ЦАХИЛГААН гэсэн салбар тус бүрээр 12 илтгэл буюу нийт 24 илтгэлийг II шатанд шалгаруулна. II шатанд шалгарсан 24 илтгэлийг илтгэгчид 1 илтгэлийг 15 минутад багтааж танилцуулах ба шүүгчдийн бүрэлдэхүүн 1-ээс 5 хүртэлх оноо өгч дүгнэн, салбар бүрээр эхний байруудыг шалгаруулна. Энэ 24 илтгэл дотроос шилдэг 1 илтгэлийг 1-р байранд шалгаруулна.

## НАЙМ. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

I байр. Нэг. – Өргөмжлөл, 2,000,000 төгрөг.

II байр. Хоёр. – Өргөмжлөл, 1,200,000 төгрөг / салбар тус бүрээр /

III байр. Хоёр. – Өргөмжлөл, 700,000 төгрөг / салбар тус бүрээр /

Тусгай байр. Дөрөв. – Өргөмжлөл, 500,000 төгрөг / салбар тул бүрээр /

Илтгэлээ ирүүлсэн хүн нэг бүр болон багын гишүүн бүрийг 50,000 төгрөгөөр урамшуулна

Ирүүлсэн илтгэлүүдийг Монголын Эрчим Хүчний Инженерүүдийн Холбооны вэб сайт дээр болон “Эрчим хүч & Engineering” сэтгүүл дээр хэвлэж олны хүртээл болгоно.

ЕС. ШҮҮГЧДИЙН БҮРЭЛДХҮҮН

Дарга: МЭХИХ-ны Гүйцэтгэх захирал	Р.Ганжуур
Гишүүд: "ДЦС-3" ТӨХК-ийн Ерөнхий инженерийн орлогч	
Үйлдвэрлэлийн албаны дарга	Л.Нямхүү
"ДЦС-4" ТӨХК-ийн Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер	Б.Дашдаваа
"MCS интернэйшнл" ХХК-ийн Эксперт	С.Цэрэнням
ШУТИС-ийн ЭХС-ийн /цахилгаан/ Монгол улсын гавьяат багш, доктор (Sc.D),	Д.Содномдорж
Монгол улсын төрийн соёрхолт	
ШУТИС-ийн ЭХС-ийн /дулаан/ Монгол улсын гавьяат багш, доктор (Sc.D),	С.Батмөнх
академич	
"Эрчим хүч & engineering" сэтгүүлийн ерөнхий редактор, доктор,	Ч.Зундуйсүрэн.
Монгол улсын төрийн соёрхолт	

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДХҮҮН

Дарга: "ДЦС-4" ТӨХК-ийн СХА-ны дарга	Г.Галбадрах
Нарийн бичгийн дарга: "ДЦС-3" ТӨХК – ийн ТБХ- ийн дарга	Г.Амартүвшин
Гишүүд: "ДЦС-3" ТӨХК – ийн инженер-багш	Д.Баярмагнай
"ДЦС-3" ТӨХК – ийн ЗХА-ны ахлах инженер	Л.Батдорж
"ДЦС-4" ТӨХК – ийн СХА-ны патентын мэргэжилтэн	В.Содномцэрэн
"ДЦС-4" ТӨХК – ийн СХА-ны Мэдээлэл технологийн менежер - 2	Н.Галцог
"MCS интернэйшнл" ХХК – ийн Инженерийн Газрын дарга	О.Шинэхүү
"MCS интернэйшнл" ХХК – ийн Төслийн Удирдлагын Газрын дарга	Н.Ганзориг
"MCS интернэйшнл" ХХК – ийн Ухаа- Худаг салбарын захирал	Ц.Идэрхуяг
МЭХИХ-ны Гүйцэтгэх захирал	Р.Ганжуур
МЭХИХ-ны Менежер	Р.Наранцэцэг
ШУТИС-ЭХС- ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга	Г.Бэхбат

-----000000-----